

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-13

---

*1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/* 3-13

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны  
07 дугаар сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 35 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Энхбаяр, С.Бямбацогт, Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар,  
Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Л.Мөнхбаатар, Ц.Сандаг-Очир;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

**Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, мөн зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Наранбилэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Б.Болормаа, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга П.Оростогоо, Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга Б.Батхүү, мөн газрын Санхүүгийн газрын дарга Ц.Чойжилсүрэн, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, референт Ц.Отгонбаатар нар байлцав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн гүйцэтгэлийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тамгын газрын дарга Ц.Адъяахишиг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 40 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 15 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
13 цаг 35 минут.

## ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

### **Ж.Сүхбаатар:**

**Ж.Сүхбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Адьшаа гишүүн ирсэн байна, Энхбаяр гишүүн томилолттой, Алтанхуяг гишүүн чөлөөтэй, Бямбацогт гишүүн томилолттой, Ганбат гишүүн ирсэн байна, Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна, Жаргалмаа гишүүн ирсэн байна, Мөнхбаатар гишүүн чөлөөтэй, Мөнх-Оргил гишүүн томилолттой, Мөнхцэцэг гишүүн өвчтэй, Нямбаатар гишүүн томилолттой, Пүрэвдорж гишүүн ирсэн, Раднаасэд гишүүн ирсэн, Сандаг-Очир гишүүн чөлөөтэй, Сүхбаатар гишүүн ирсэн, Сэргэлэн гишүүн ирсэн, Учрал гишүүн ирсэн, Цогтбаатар гишүүн томилолттой, Б.Энх-Амгалан гишүүн ирсэн. Ийм байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол

Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Энэ санал дүгнэлтээ бид нар энэ төсвийн энэ хоёр дахь хэлэлцүүлгийг хийгээд гүйцэтгэлийг хэлэлцээд тэгээд Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэхээр байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Энэ танилцуулж байх хооронд манай зарим албан тушаалтан нь ороод ирэх байх. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Баянбилиг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Батрагчаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сайнзориг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж буй ерөнхий нягтлан бодогч Наранбилиг, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Мөнхзориг байна уу. Байхгүй бол дуудаарай. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга Гансэлэм, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга Баасанням ирсэн байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тамгын газрын дарга Адьаахишиг ирсэн байна. Шүүхийн сахилгын хорооны ерөнхий нягтлан бодогч Ариунжаргал, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын

албаны дарга Очирсүрэн. Очирсүрэн байна уу. Очирсүрэн байхгүй байна шүү. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Эрдэнэчимэг, Цагдаагийн ерөнхий газрын дарга Болд, Цагдаагийн ерөнхий газраас хэн орсон юм. Болд алга. Хэн гэнээ. Тэр юуг нь тэмдэглэж аваарай. Цагдаагийн ерөнхий газраас ирсэн хүнийх нь сая микрофонд хэлээгүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Амарсанаа. Амарсанаа байхгүй бол Амарсанаагийн оронд хэн ирсэн юм. Энэ чинь Амарсанаа чинь генерал болсон. Айн үгүй бил үү. Цэцийн нягтлан бодогч Эрдэнэбат, Цэцийн Тамгын дарга ирчихсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Болормаа, Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга Батхүү, Цагдаагийн ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга гээд Алтансүх гэсэн тээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүүгийн газрын дарга Батбаяр, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүүгийн газрын дарга Чойжилсүрэн. Ингээд хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Одоо Нэгдсэн төсвийн гүйцэтгэл дээр Жавхлан сайдыг урья. Засгийн газрын санхүүгийн нэгдсэн танилцуулга Жавхлан сайд танилцуулна. Дараа нь Занданбат Ерөнхий аудитор Занданбат дарга танилцуулна шүү дээ. Тэгэхээр энэ хоёрыг бас урьчих хэрэгтэй байна.

Жавхлан сайдыг урьж байна. Сангийн яамны улсууд бусад улсууд явж байсан шүү дээ түрүүн. Тэд нар руу бас хэлчих.

Жавхаа сайд ирж явна. Жавхаа сайд ирж явна гэж байна Ганбат гишүүнээ. Одоо ороод ирлээ. Жавхаа сайдаа мөн мөн. Таныг чинь энд.

Сангийн сайд Жавхлан сайд Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг хийнэ. Дараа нь

Занданбат дарга бэлдэж байгаарай. Тийм.

**Б.Жавхлан:** Эрхэм Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 7 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт танилцуулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17.1 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 1861 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөгдсөн дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр буурсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газрын дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга болон Шүүхийн сахилгын хорооны даргын багцын нийт 282 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 876.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 801.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 74.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 78 хувь буюу 683.9 тэрбум төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, 8.4 хувь буюу 73.6 тэрбум төгрөгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, 6.4 хувь буюу 55.8 тэрбум төгрөгийг Улсын Ерөнхий прокурор, 7.2 хувь буюу 63.1 тэрбум төгрөгийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 851.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 28.6 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 1.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Сүхбаатар:** Жавхлан сайдын дараа Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. 4 номерын микрофоныг нээе.

**Д.Занданбат:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хорооны харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 230 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 171 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 59 байгууллагыг аудитын түүвэрт хамруулаа.

Аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 166 байгууллагад өөрчлөлтгүй, 5 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгч, нийт 8.4 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс 3.3 тэрбум төгрөгийн 25 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 тэрбум төгрөгийн 97 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 237 зөвлөмж өгч, хариуцлага тооцох 2 албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 0.4 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага өгсөн. Нийцлийн асуудлаар 9.1 тэрбум төгрөгийн 105 зөрчил илэрснээс 2.9 тэрбум төгрөгийн 18 шаардлага, 6.2 тэрбум төгрөгийн 84 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4.2 тэрбум төгрөгийн 128 алдаа илэрснээс аудитын явцад 4.1 тэрбум төгрөгийн 112 алдааг залруулж, 100 сая төгрөгийн алдааг ахин давтан гаргахгүй байх 16 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 120.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 62.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 44 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

Үүнээс ишилжин хэрэгжих 33.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 9 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжих 87.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 49.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 35 төсөл, арга хэмжээ байна.

Нийт төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 99 хувьтай бүрэн хэрэгжиж дууссан 22, хэрэгжилт дутуу болон хэрэгжээгүй 22 төсөл арга хэмжээ байна. Төсөл, арга хэмжээний 2022 оны санхүүжилтийн гүйцэтгэл 99.3 хувь байна.

2.Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 44 санхүүгийн тайланд нэгтгэгдсэнээс 40 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан. Аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 37 байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт, 3 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгч, нийт 0.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 40 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 200 сая төгрөгийн зөрчилд 20 албан шаардлага хүргүүлж, 200 сая төгрөгийн зөрчилд 51 зөвлөмж, хариуцлага тооцох 1 албан шаардлага, 1 зөрчлийг хууль, хяналтын байгууллагад өгсөн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 0.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэнд хариуцлага тооцох 1 албан шаардлага өгсөн. Нийцлийн асуудлаар 1.3 тэрбум төгрөгийн 105 зөрчил илэрсэнд.../ үг тасрав.

**Ж.Сүхбаатар:** Байж байгаарай Занданбатаа. Үгүй чи энэ хамаагүй энэ хуралдааны дундуур ингээд наагуур цаагуур яваад байх юм наадах чинь бас энэ Байнгын хороо чинь өөрийн дэгтэй байхгүй юу. Тэгээд л ерөөсөө хөндлөн давхиад байх юм. Тэх. Үргэлжлүүлээд ярья.

**Д.Занданбат:** Нийцлийн асуудлаар 1.3 тэрбум төгрөгийн 105 зөрчил илэрсэнд 0.6 тэрбум төгрөгийн 10 албан шаардлага, 0.7 тэрбум төгрөгийн 31 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 500 сая төгрөгийн 38 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 14.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс шинээр хэрэгжих 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ байна. Нийт төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 91 хувьтай бүрэн хэрэгжиж дууссан 2, хэрэгжилт дутуу 2 төсөл, арга хэмжээ байна. Төсөл, арга хэмжээний 2022 оны санхүүжилтийн гүйцэтгэл 98.9 хувь байна.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 44 санхүүгийн тайланд нэгтгэгдсэнээс 40 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 39 байгууллагад өөрчлөлтгүй, 1 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгч, нийт 0.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 0.6 тэрбум төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 23 албан шаардлага хүргүүлж, 0.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 35 зөвлөмж өгч, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийцлийн асуудлаар 0.8 тэрбум төгрөгийн 14 зөрчилд илэрсэнд зөвлөмж өглөө. Нягтлан бодох бүртгэлд тайлагналтай холбоотой 2.3 тэрбум

төгрөгийн 42 алдаа илэрснээс аудитын явцад 2.3 тэрбум төгрөгийн 38 алдааг залруулж, 20 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна. Нийт төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 100 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 68.2 хувьтай байна.

4.Хүний эрхийн Үндэсний комиссын даргын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгч, нийт 27.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 16.1 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэлд тайлагналтай холбоотой 45.7 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 142 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 100 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 100 хувь байна.

5.Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгч, нийт 25.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 22 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 3.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийцлийн асуудлаар 2 зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэлд тайлагналтай холбоотой 51.6 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 743.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан. Төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 100 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 100 хувь байна.

6.Авлигатай тэмцэх газрын даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 тэрбум 43 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан. Ажлын бодит гүйцэтгэл 100 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 54.8 хувьтай байна.

7.Шүүхийн сахилгын хорооны даргын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Нийт 34.8 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 23.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 11.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Нийцлийн асуудлаар 117 сая төгрөгийн 2 зөрчил илэрснээс 105.7 сая төгрөгийн зөрчил албан шаардлага хүргүүлж, 1.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан. Ажлын бодит гүйцэтгэл 100 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 93.6 хувьтай байна.

8.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хязгаарлалттай дүгнэлт өгч, нийт 154.3



сая төгрөгийн алдаа илэрснээс 1.3 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 63.4 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 89.4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Нийцлийн асуудлаар 15 тэрбум 306.3 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 30.1 сая төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

9.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгч, илэрсэн 1 зөвлөмж өглөө. Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 2 зөвлөмж өглөө. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 31.1 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудит явцад залрууллаа.

Аудитын дүн дүгнэлтээс нэн тэргүүнд анхаарах асуудлыг тоймлон танилцуулъя.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны нэг болж байна.

Орхигдсон болон олон жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээг богино хугацаанд ашиглалтад оруулах шийдлийг гаргахгүй байгаа нь төсвийн санхүүжилт, үр дүнгүй зарцуулагдах үр дагавар үүсэхээр байна. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, мөн төсөвт ачаалал үүсэж буй талаар жил бүр хийгдэж буй аудитын өгсөн

дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангахгүй зөрчсөн хэвээр байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Сүхбаатар:** Баярлалаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлттэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Пүрэвдорж гишүүнээр тасалъя.

Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Бид нар өнөөдөр Хууль зүйн байнгын хороон дээр энэ хууль, хяналтын байгууллагын 22 онд төсвийн гүйцэтгэлийн талаар ярьж байна 22 оны. Аудитын дүгнэлтийг сонслоо. Их л олон зөрчил, дутагдал гарсан байна. Тэгээд энэний үр дүнд мэдээж хэрэг аудит өөрөө энэ дүгнэлтээ гаргаад явуулаад, хууль, хяналтын байгууллагад хандах ёстой. Энэ их мөнгө төгрөг явж байхад. Тэгээд тэрний дагуу ямар нэгэн ял шийтгэл авсан ийм албан хаагч байна уу энэ хууль, хяналтын байгууллагаас. Манай, би баахан тоо яриад яах вэ дээ ард түмэн ойлгох ч үгүй. Гэхдээ энэ дарга нар бол үнэхээр голийсон байгаа юм байна, улам л их мөнгө зарцуулдаг болсон юм байна гэдгийг ард түмэн харж байна, мэдээж байна.

Гэтэл яг өнөөдөр энэ хуулийн хэрэгжилт ямар байна вэ. Хүний эрх ямар байна вэ. Энэ зүйл алга байна шүү дээ. Хууль, хяналтын байгууллагын энэ шүүх энэ юман дээр дандаа л Увс, Хэнтийнхэн овоорчихсон баахан дарга нар байгаа юм. Энэ бол бараг л авлига шүү дээ. Тэгээд жирийн иргэдийг яллаад байдаг. Энэ Хууль зүйн яам ч гэсэн. Эд нар бүх юмаа мэддэг болчихсон юм уу, хууль зүйн салбар тийм сайн байгаа юм уу. Тэгээд л Төрийн нарийн бичиг нь тэнд Өмнөговьд орон нутгийн өмчтэй компанид БЭТ хийгээд л явж байх жишээтэй. Үгүй тэр чинь аж ахуйн нэгж чинь шал өөр салбар шүү дээ.

Өмнөх ажлаа хийхгүй байж байж бусад салбар руу ингээд яваад байдаг. Тэгээд энэ томилолт, зардлыг нь яадаг юм, хаанаас гаргадаг юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ сая баахан Хөгжлийн банктэй холбогдоод би зүгээр энгийн хэдэн юм л юм ярья. Сонсгол явлаа, тэгээд тэр шүүхийн Сүхбаатар дүүргийн шүүх шүүв яав. Тэгээд 80-аад хүн тэрийг шүүлээ. Шүүхийн зориулалтын байранд нь шүүхгүй, шоу маягтай Соёлын төв дээр ингээд шүү шүүлээ 30, 40 хоног, бараг 50, 60 хоног явагдлаа. Нийтдээ 80-аад хүн тэрэнд хамрагдаж байгаа. Тэрний 32 нь гэм буруутай гэж гарч байгаа, 48 нь гэм буруугүй гэж байгаа юм.

Тэгээд шүүх ийм байна уу, эсвэл энэ улсаас татвар төлөгчдийн мөнгийг тавиад өгч байгаа энэ мөнгө төгрөгийг энэ прокурор, хууль, хяналтын байгууллага, Авлигатай тэмцэх газар, энэ цагдаа ингэж үр дүнгүй зарцуулаад байна уу гэсэн ийм асуулт байгаа юм.

Одоо ингээд мөнгө төгрөг бага байна гээд байгаа юм. Тэгсэн мөртөө аймгуудаас шүүгч нарыг томилолт хийгээд Улаанбаатарт авчраад шүүж байгаа юм. Үгээ хэлсэн, үзэл бодлоо илэрхийлсэн ийм залуучуудыг шүүгээд ял өгөөд байх юм. Нөгөө авлига авсан, нөгөө мөнгө хөрөнгийг нь хулгайлсан ийм улсууд бараг хэрэг угаалгана гэдэг шиг ингээд чөлөөтэй гараад яваад байгаа юм. Ийм л нөхцөлд байна. Би зүгээр жирийн жишээ татъя. Манай Мөнх-Эрдэнийг яагаад манай гэж байгаа Баянхонгорынх болохоор би хэлж байгаа юм. Үгээ хэлээд, үзэл бодлоо илэрхийлсний төлөө тэр хүнийг тэгээд яллаж байна шүү дээ. Тэгэхдээ Архангай аймгаас шүүгч дуудаж ирээд яллуулж байгаа байхгүй юу. Би хангалттай дуугүй байлаа.

**Ж.Сүхбаатар:** Тэр холбогдох асуултад нь Занданбат Ерөнхий аудитор 4 номерын микрофон. Хэн нь яаж байна өөрийгөө, Наран өөрийгөө танилцуулаад тэгвэл наанаа.

**Ц.Наранчимэг:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

2022 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 30 тэрбум төгрөгийн 25 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн. Хууль, хяналтын байгууллага хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллээ Монгол Улсын Ерөнхий прокурор өнөөдөр манай Монгол Улсын Ерөнхий аудиторт ирүүлсэн байгаа.

Яг энэ Байнгын хороонд харьяалагдаж байгаа байгууллагуудаас хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн, шалгуулсан асуудал бол байхгүй байна.

**Ж.Сүхбаатар:** Ганбат гишүүн тодруулъя. Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Би улсын төсвийн хөрөнгийг хууль, хяналтын байгууллагууд энэ шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл ямар үр дүнтэй зарцуулж байгаа вэ гэж л асуугаад байгаа шүү дээ. Бид нар баахан тоо ярихаас гадна яг амьдрал дээр ямар байна гэдгийг харах ёстой байхгүй юу. Тэрийг л би асуугаад байгаа юм. Гэмт хэргийн нөхцөл байдал багассан уу, эхэлсэн үү. Одоо жирийн цагдаа, эргүүлийн цагдаа, жирийн мөрдөгч нар тэд нарын амьдрал ахуй бол маш хүнд байдаг. Тэд нарын ажиллах нөхцөл энэ тэр сайжирсан уу. Анхан шатын шүүгч нар ажлаа хэвийн явуулаад байдаг. Энэ давж заалдах, Дээд шүүх эд нарыг би ажлаа хийхгүй байна гэж байгаа юм. Хүний эрхийн байгууллагыг бид нар байгуулаад өгсөн. Тэд нар үр дүнтэй ажиллаж байна уу. Төсвийг нь нэмээд өгсөн.

**Ж.Сүхбаатар:** Тодорхой саналууд бас хэлж байх шиг байна. Сайнзориг ер нь тэр цагдаа, тэр юутай эд нартай нь холбоотой асуудлаа хариулчихъя. Гэмт хэргийн нөхцөл байдал тэгээд хэр байсан юм бэ. Төсөв зарцуулаад байна, нэмээд

байдаг гээд тэгж байна шүү дээ. 3, хэд билээ энэ чинь гялтайгаад харагддаггүй. Хэд вэ. 2 номерын микрофон.

**П.Сайнзориг:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал ер нь бас тодорхой түвшинд буурсан үзүүлэлттэй байгаа. Илрүүлэлт өсөж байгаа үзүүлэлт байгаа.

Гэхдээ сүүлийн үед үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд энэ цахим орчинд үйлдэгдэх байдал руу орсон. Энийгээ дагаад хохирлын хэмжээ болон яг хохирсон иргэдийн тоо нэмэгдэх гэдэг юм уу ер нь ийм тал руугаа бас нэлээдгүй шилжсэн. Өмчийн эсрэг гэмт хэргүүд тэр дундаа залилан мэхлэх гэмт хэргүүд цахим орчин руу шилжсэн байж байгаа. Энэ чиглэлдээ бас бас тодорхой хэмжээний арга хэмжээнүүд авч байгаа төсөв мөнгө бас хуваарилж байгаа.

Ерөнхийдөө бас гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх чиглэлд бас Засгийн газраас бас боломжийн хэмжээндээ л энэ төсөв мөнгийг хуваарилж, зохих хэмжээнд бас алба хаагчдыг бас ажиллах нөхцөл бололцоогоор хангаж байгаа гэж хэлж болно. Өнгөрсөн жилүүдэд мэдээж бас цагдаагийн бие бүрэлдэхүүн бас КОВИД-ын нөхцөл байдлын үед ч бас цаг наргүй ажилласан. Дээрээс нь нэг бүрийн тусгай хэрэгсэл ч гэдэг юм уу яаг.../минут дуусав./

**Ж.Сүхбаатар:** Гүйцээгээд яачих. Та нар 2 номерын микрофоныг нээчих.

**П.Сайнзориг:** Ажиллаж байсан. Тэгэхээр бас дутмаг ийм зүйлүүд байсныг бас тодорхой үе шаттайгаар шийдсэн байж байгаа. Өнөөдөр бас ахлагч бүрэлдэхүүн болоод бас дунд, дундаас доош түвшиний энэ алба хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлсэн. Тодорхой хэмжээнд бас албандаа итгэх итгэл бас нэг бол хэсэг цалингийн энэ бага юунаас бас алба хаагчид бас ажлаас гарах ийм нөхцөл байдал руу байсан бол одоо бас

харьцангуй тогтвортой байдал руу бас орж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлмээр байна.

Ер нь зүгээр Хууль зүй, дотоод хэргийн салбарын хэмжээнд бол шийдэх асуудлууд нэлээд байгаа. Таны бас дурдаж байгаа тэр шүүхийн асуудал ялангуяа энэ шүүхийн барилга ба дэд бүтцийн асуудал Шүүхийн хуулийг дагаад ч бас яригдаж байсан. Энэ чиглэлдээ бас цаашидаа анхаарахгүй бол шүүх хуралдааныг стандартын бус танхимд хийдэг. Ер нь зүгээр гэр бүлийн хэрэг маргааныг ч гэсэн бас өөр байдлаар буюу хохирогч эргээд энэ тухайн хэрэг, маргааныг шийдэж байгаа оролцогч бас нэг хаалгаар гарч, нэг хаалгаар гардаг ч гэдэг юм уу, шүүгчтэйгээ бараг нүүр тулаад суучихсан ч гэдэг юм уу, энэ шүүхийн үйлчилгээний чанарын асуудал дээр зайлиггүй энэ дэд бүтцийн асуудлаасаа шалтгаалаад нөлөөлж байгаа хүний эрх зөрчигдөж байгаа зүйлүүд бас, зөрчигдөж болиггүй ийм зүйлүүд гарч байгаа гэдэг зүйлтэй тантай санал нэг байна.

Тэгээд цаашидаа бас энэ шүүхийн асуудал ялангуяа энэ шүүх энэ шүүх рүү оруулж байгаа бүтээгдэхүүнийг бий болгож байгаа мөрдөх албаасаа эхлээд прокурор, шүүхийн байгууллага Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын энэ цахимжилтын асуудлыг цаашидаа бас иж бүрнээр нь шийдэж байж таны хэлж байгаа бас энэ том зорилтууд, ялангуяа энэ үйлчилгээг түргэн шуурхай энэ дундаа хүний эрх зөрчигдөхгүй байх ийм чиглэлд нь бас анхаарч ажиллах зайлиггүй шаардлага байгаа.

Тэгэхдээ тодорхой хэмжээнд бас хууль зүйн салбар гэмт хэрэгтэй тэмцэх, хүний эрхийг хангах энэ чиглэлдээ бас тодорхой үр дүн гаргасан гэж бас хэлж дүгнэж хэлмээр байна.

**Ж.Сүхбаатар:** Тэр Хүний эрхийн Үндэсний комиссын тэр урагшаа суучих. Тэр саяын бас Ганбат гишүүний илэрхийлэл түрүүн дуусаагүй л дээ. Төсөв

ингээд тодорхой төсвийн гүйцэтгэл гээд гарч байна, тэгээд төсвөө зарцуулж байна. Үр дүн яачхав, хүний эрх зөрчигдөж байна. Тэр Мөнх-Эрдэнэ гээд Баянхонгорын нутгийн нөхөр байж байна. Гэтэл одоо ингээд тэр хүний эрх гэхэд ийм байна ч гэдэг юм уу ингээд асуудлууд ярьж байна шүү дээ.

Тэгэхээр танай Хүний эрхийн Үндэсний комисс 22 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга ингээд хийгдэж байгаа учраас саяын энэ асуудлууд, зөрчлүүд тэд нар дээр ямар арга хэмжээ авч байгаа юм. Бас товч тэр гишүүний асуултад хариулчих. Тэр Мөнх-Эрдэнэтэй холбоотой асуудал дээр ч гэсэн Их Хурлын дарга бас үүрэг, чиглэл өгөөд л байсан юм шүү дээ. Тэгээд юу болсон, яасан ийсэн юм тийм. Тэр зориуд шүүгч татаж авчраад байсан гээд л сэжигтэй юм яриад байна шүү дээ. Тэгэхээр та хэд бас өөрсдийнхөө тэр ажилласан талын юмыг нь мэдээллийг нь өгөөч. 1 үү, хэд вэ. Тэр ажлын хэсгийн микрофоныг нээчих. Наадах чинь нээгдчихлээ.

**Ц.Адъяахишиг:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Хүний эрхийн Үндэсний комиссын тамгын газрын дарга Адъяахишиг байна. Хүний эрхийн Үндэсний комисс өнгөрсөн хугацаанд иргэд, олон нийтээс 1075 орчим гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Ялангуяа гишүүний асууж байгаа иргэн Мөнх-Эрдэнийн асуудал дээр бол Хүний эрхийн Үндэсний комисс Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдалд хяналт, үнэлгээ, дүгнэлт өгөх үүднээс тухайн иргэнтэй бол цагдан хоригдсон тухайн мөчөөс нь очиж нөхцөл байдлыг бол тодруулах, нөхцөл байдалд нь үнэлгээ хийх ажлуудыг Комиссын Хүний эрхийн хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Дондов хариуцан ажиллаж, мэдээллүүдээ олон нийтэд тухай бүр нь өгөөд ажилласан байж байгаа.

**Ж.Сүхбаатар:** Асуулт асууж дууслаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Ганбат гишүүнээр үг хэлэх гишүүнийг тасалъя. Ганбат гишүүн

**Д.Ганбат:** Бид нар 22 оны төсвийн гүйцэтгэл ярьж байна. Энэ төсвийн гүйцэтгэл дээр бид нар хэдэн тоо баримт ярихаас гадна энэ мөнгө төгрөг, татвар төлөгчдийн мөнгө төгрөг хаашаа чиглээд, ямар үр дүнтэй зарцуулагдаад тэрний үр дүн нь яаж гарч байна вэ гэдгийг бас ярих ёстой. Тэрний нэг нь бол өнөөдрийн гэмт хэргийн нөхцөл байдал ямар байна вэ. Иргэдийг бид нарын гол зорилго хууль, хяналтын байгууллагын хуулийг хэлбэрэлтгүй дээдэлж ингэж ажиллах шүү дээ. Хэдэн дарга нарыг зөвтгөх ч юм уу, хамгаалах, тэд нарын гэмт хэргийг нуун дарагдуулах, тэд нарын гэмт хэргийг угаах биш энэ шүүх энэ хууль, хяналтын байгууллага биш.

Иргэдийг, хүний эрхийг бид нар дээдэлж ажиллах ёстой. Энэ татвар төлөгчдийн мөнгө нь өөрсдөө тэрэнд зориулагдаж байх ёстой байхгүй юу. Хуулийнхаа дагуу. Тэрийг эсрэгээр нь захиран зарцуулдаг. Ялангуяа хууль, хяналтын байгууллага гэдгийг олон жил, удаан жил бүлэглэлийн гарт өгчихсөн. Орон нутгийн, Увсын, Хэнтийн ийм юм бол олон жил ажиглагдаж байна Би түрүүн хэллээ шүү дээ. Хууль зүйн яам нь өөрийнхөө урдах ажлаа дийлэхгүй байж байж тэр аж ахуйн нэгж рүү, орон нутгийн өмчтэй компани компани руу Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийг томилоод явуулж байдаг. Үгүй энэ юу юм бэ, энэ чинь хэдэн он бэ. Юу яасныг чинь 37 он юм уу, онцгой комисс юм уу иймэрхүү маягтай улсын мөнгө төгрөгийг зарцуулж байдаг. Шүүх гэхэд хаа байгаа хөдөө орон нутгаас шүүгчийг Улаанбаатар татаж авчраад мөнгө төгрөг муутай юм уу гэтэл тэгж зарцуулж байдаг.

Тэгээд дараа нь Улаанбаатарт тэр хүнийг үлдээнэ гэж ингэж ярьж байдаг. Хэвлэл мэдээллийн байгууллагын үндсэн дээр тэр дээр ярьж байна шүү дээ. Зүгээр театрыг, соёлын төвийг шүүхийн шүүн таслах үйл ажиллагаа явуулдаг төв болгоод, тэгээд бөмбөгөр ногоон тэрэг шийддэг шиг шийдэж байгаа. Тэрнээс нь үр дүнг нь харахад зүгээр тухайн үеийн Хөгжлийн банканд ажиллаж байсан хэдэн хүн л ял авч байгаа шүү дээ. Бараг дунд шатын гүйцэтгэгч нар нөгөө шийдвэр гаргадаг энэ тэр хүмүүс нь цаана нь зүгээр л үлдэж байна. Намайг би Ардчилсан намын бүлгийн дарга байхад энэ манай Ардчилсан намын маш олон хүнийг 16-20 онд хэлмэгдүүлсэн байсан. Энэ бүх юмыг цэгцлээд нэг талд нь гаргаад ингээд манай үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлдэг энэ хүмүүс бол хэлмэгдсэн байснаа цагаатгагдсан.

Одоо эргээд энэ хүмүүсийг энэ талаар хэлэхгүй, ярихгүй, дуугүй яваад байх тусам л ингээд аваачаад хийгээд байна. Нөгөө хулгайлсан, идсэн, уусан, завхсан энэ хүмүүс чинь зүгээр мөнгө угаадаг гэдэг шиг хэргээ угаалгаад ингээд зугаалаад байдаг. Энэ дарга нарын болохгүй, бүтэхгүй байгаа юмыг ярьдаг, хэлдэг ийм хүнийг чи хэллээ, ярилаа гэдэг шиг жоохон юманд өөнтөглөөд аваачаад ямар нэгэн шалтаг, шалтгаанаар буруутгаад ингээд орон шоронд ингээд хорьдог. Улсын төсөв мөнгийг, татвар төлөгчдийн мөнгийг ийм юманд зарцуулж болохгүй. Ийм ч байх ёсгүй. Та бүхний хийх ёстой ажил бол энэ татвар төлөгчдийн мөнгийг тэр хуулийг дээдэлж, иргэний эрхийг хамгаалж, хүний эрхийг дээдэлж, ингэж л ажиллах ёстой байхгүй юу.

Тийм болохоор чинь наад сүүлийн 7, 8 жил энэ хууль, хяналтын байгууллагад чадалтай, чадвартай хүмүүс ажиллах нь багасчихсан байна шүү дээ. Хүсэлгүй болчихсон байна. Ийм нөхцөл байдал бий болчихоод байна. Тэгээд хуулийг дээдэлж биш дарга нарын үгээр ажилладаг, тэгээд орон нутгийнхаа

тэрийг бараг авлига гэж хэлсэн ч болно шүү дээ. Ер нь авлигын нэг төрөл шүү дээ. Баахан аймаг, сумын нөхдүүд бие биеэ дарга, цэргээр тавьчихдаг. Энийг бүгдээрээ Монгол даяар л мэдэж байгаа шүү дээ. Цагдаагийн дарга нь хаанахын хүн юм, Авлигатай тэмцэх газрын даргынх нь хаанахын хүн юм, тэр шүүх дээр ямар шүүгч нар овоорчихсон байна, Шүүхийн ерөнхий зөвлөл нь ямар байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн талаар хууль батлаад л явуулсан. Эндээс томилогдсон хүмүүс л дандаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга ээлж дараагүй хийгээд байж байгаа шүү дээ. Тэр яагаад шүүгч нараас нь томилж болдоггүй юм ээлжлээд. Уул нь тийм нөхцөл байдал үүсгэхийн тулд л.../минут дуусав./

**Ж.Сүхбаатар:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой гишүүд үг хэлж дууслаа. Саяын энэ юун дээр бол Ганбат гишүүн маань төсвийн гүйцэтгэл буюу санхүүгийн сахилгатай холбогдуулаад цаад ажлын үр дүн ямар байгаа тухай асуудлаар Байнгын хорооныхоо гишүүнийхээ хувьд бол бас байр сууриа илэрхийллээ. Улс төрийн өнгө аяс байгаа ч гэсэн тэр дээр бас манайх анхаарна биз.

Ер нь төсвийн сахилгын талаар, санхүүгийн сахилгын талаар бол аудитын дүгнэлтэд тодорхой зөрчил, дутагдлууд гарсан. Гэхдээ яг хуулийн, хууль зөрчөөд хуулийн байгууллагад шилжчихсэн манай Хууль зүйн байнгын хорооны эхлэх асуудлын хүрээнд бол алга байна гэдгийг сая танилцууллаа.

Ийм учраас Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх хоёр дахь хэлэлцүүлгийг Байнгын хороон дээр манай Байнгын хороо явуулж дууслаа.

Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн

*зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн манай Пүрэвдорж гишүүн өөрөө байдаг юм чинь Пүрэвдорж гишүүн танилцуулна. Ингээд хуралдаанд оролцсон оролцогчдод болон гишүүдэд баярлалаа.*

*Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.*

*14.15 цаг*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*